

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮДЭД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн хуралдааны 56 дугаар тэмдэглэлд:

“XIII.7. “Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 1 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийн явцыг Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад даалгав:

1. Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай албан даалгаврын заалт бүрт холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, хөтөлбөртэй уялдуулсан нарийвчилсан төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх;

2. Төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний үр дүнг чанарын үзүүлэлтээр тооцох боломжтой, хэмжигдэхүйц байхаар тодорхойлох;

3. Харьяа байгууллага, албан тушаалтнуудад төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах талаар тодорхой үүрэг, чиглэл өгч, хэрэгжилтэд хяналт тавьж, салбарын болон нутаг дэвсгэрийн хэмжээнд дүгнэж үр дүнг бодитойгоор бүрэн тайлагнах;

4. Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах чиглэлээр зарим ахиц дэвшил гарч байгаа тухай тодорхой мэдээллийг олон нийтэд хүргэх.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР